



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

9-Р САР

Э-сонин

62-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.09.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	20,681,370,215.9
Хувьцаа /анхдагч/	16,486,379,200.0
Хувьцаа /хоёрдогч/	3,890,684,495.9
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	304,306,520.0
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	24,339,213.0
Хувьцаа /анхдагч/	13,466,354.0
Хувьцаа /хоёрдогч/	10,869,830.0
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	3,029
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	6,163


Зах зээлийн үнэлгээ



TOP-20 индекс




MSE A индекс



/Нэгж/

MSE B индекс



/Нэгж/

Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	222
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	119
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	59
Үүнээс:	
Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.09.30-ны байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	БиДиСек ХК	1,124,511	1,394,980,499	5,391,201	1,818,011,126	3,212,991,625
2	Бумбат-Алтай ХХК	981,106	556,859,714	968,884	225,965,711	782,825,425
3	Голомт Капитал ХХК	515,886	324,964,942	664,815	426,073,201	751,038,144
4	Ти Ди Би Капитал ХХК	456,104	227,558,147	589,013	241,567,643	469,125,791
5	Новел инвестмент ХХК	472,294	219,456,904	363,523	118,485,720	337,942,624
6	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	1,581,406	173,637,084	1,218,841	155,575,385	329,212,468
7	Гаули ХХК	657,778	217,119,682	206,861	87,501,814	304,621,496
8	Стандарт инвестмент ХХК	337,456	147,088,440	350,185	152,392,096	299,480,535
9	Ард капитал групп ХХК	4,317,272	236,256,958	80,788	61,036,477	297,293,435
10	Ард секюритиз ХХК	98,263	101,088,803	100,616	63,887,850	164,976,653
11	Санар ХХК	141	876,730	253,283	138,618,956	139,495,686
12	Апекс	151,016	83,767,629	39,802	20,247,977	104,015,606
13	Гүүдсек ХХК	6,656	3,396,905	128,402	70,771,207	74,168,112
14	Монсек ХХК	38,402	21,860,638	92,871	39,094,580	60,955,217
15	Дархан брокер ХХК	33,545	27,281,746	43,446	29,165,284	56,447,030
16	Эм Ай Би Жи ХХК	35,601	24,075,900	55,457	19,973,520	44,049,420
17	Нэйшнл сэкюритис ХХК	4,350	8,222,347	25,379	30,443,237	38,665,584
18	Зэргэд ХХК	3,300	7,207,192	59,914	26,781,544	33,988,736
19	Лайфтайм инвестмент ХХК	3,838	20,308,730	17,504	9,702,613	30,011,343
20	Гендеке ХХК	4,961	8,802,279	30,416	19,264,638	28,066,917

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.09.30-ны байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	MMX	МАХИМПЕКС	423,699	1,014,877,712	2,685.00	2,083.00	-207.00	-7.96
2	GOV	ГОВЬ	15,183	491,592,680	34,860.00	29,500.00	2,680.00	8.69
3	APU	АПУ	744,836	413,664,939	600.00	520.00	-2.82	-0.49
4	MCH	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	550,068	298,175,535	560.00	521.00	5.00	0.93
5	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	681,505	227,786,842	349.00	300.00	-6.91	-2.01
6	HBO	ХАЙ БИ ОЙЛ	4,184,234	205,121,766	62.00	49.00	-8.00	-14.04
7	TTL	ТАВАН ТОЛГОЙ	25,766	195,534,375	8,300.00	6,510.00	475.00	6.92
8	LEND	ЛЭНДМН ББСБ	2,804,758	187,879,942	70.00	65.00	-2.62	-3.82
9	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС	238,711	152,093,781	658.00	580.00	-51.90	-8.15
10	HHN	ХАРХОРИН	101,634	142,287,600	1,400.00	1,400.00	0.00	0.00
11	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	26,091	129,861,145	5,095	4,600	-98.00	-2.04
12	ADU	АЛТАНДУУЛИГА	159,162	92,833,425	977.00	540.00	-70.00	-8.24
13	JIV	ЖИНСТ УВС	46,500	74,586,221	1,750.00	1,450.00	200.00	13.61
14	SUU	СҮҮ	158,550	33,706,051	230.00	205.00	8.71	4.06
15	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	56,702	30,802,784	590.00	540.00	-48.88	-8.28
16	DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	30,879	24,703,200	800.00	800.00	20.00	2.56
17	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	40,671	20,195,748	525.00	460.00	14.41	2.88
18	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	121,174	18,150,656	156.00	148.00	2.00	1.37
19	ITLS	АЙТҮҮЛС	150,642	17,873,555	128.00	109.00	4.47	3.87
20	BDS	БИДИСЕК	16,322	15,666,895	1,000.00	900.00	-95.84	-9.58



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.09.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт %/
			2018-09-01	2018-09-30		
1	АЛТАЙН ЗАМ	3	9,845.00	13,010.00	3,165.00	32.15
2	АТАР ӨРГӨӨ	67	60,500.00	70,000.00	9,500.00	15.70
3	ДОРНОД ИМПЕКС	2	120.75	138.86	18.11	15.00
4	ГАН ХЭРЛЭН	74	3,838.00	4,413.00	575.00	14.98
5	ТАЛХ ЧИХЭР	704	20,000.00	22,820.00	2,820.00	14.10
6	ЖИНСТ УВС	46,500	1,470.00	1,670.00	200.00	13.61
7	ХЭРЛЭН ХИВС	3	85.00	94.00	9.00	10.59
8	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	50	90,080.00	98,000.00	7,920.00	8.79
9	ГОВЬ	15,183	30,840.00	33,520.00	2,680.00	8.69
10	УУЖИМ ХАНГАЙ	62,100	250.00	270.00	20.00	8.00
11	ТАВАН ТОЛГОЙ	25,766	6,865.00	7,340.00	475.00	6.92
12	МАТЕРИАЛИМПЕКС	671	9,500.00	10,000.00	500.00	5.26
13	УСЖУУЛАХ	98	665.00	700.00	35.00	5.26
14	СҮҮ	158,550	214.45	223.16	8.71	4.06
15	АЙТҮҮЛС	150,642	115.53	120.00	4.47	3.87
16	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	40,671	500.00	514.41	14.41	2.88
17	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	30,879	780.00	800.00	20.00	2.56
18	ГЕРМЕС ЦЕНТР	121,174	146.00	148.00	2.00	1.37
19	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	550,068	540.00	545.00	5.00	0.93
20	МОНИНЖБАР	204	189.00	190.00	1.00	0.53

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.09.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-09-01	2018-09-30		
1	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	6,600	280.00	210.00	-70.00	-25.00
2	МОНГОЛ ШИЛТГЭЭН	300	400.00	300.00	-100.00	-25.00
3	МОГОЙН ГОЛ	211	7,300.00	5,530.00	-1,770.00	-24.25
4	БАГАНУУР	2,589	1,770.00	1,350.00	-420.00	-23.73
5	УВС ЧАЦАРГАНА	27	675.00	525.00	-150.00	-22.22
6	Э- ТРАНС ЛОЖИСТИКС	25,672	82.00	66.00	-16.00	-19.51
7	ШИВЭЭ ОВОО	850	2,000.00	1,700.00	-300.00	-15.00
8	МОНГОЛ САВХИ	192	900.00	765.00	-135.00	-15.00
9	МОНГОЛ НЭХМЭЛ	1	3,700.00	3,145.00	-555.00	-15.00
10	ТАВ	2	15,400.00	13,100.00	-2,300.00	-14.94
11	ХӨХ ГАН	74,725	108.00	92.00	-16.00	-14.81
12	ЭРЭЭНЦАВ	1	6,270.00	5,350.00	-920.00	-14.67
13	ШАРЫН ГОЛ	1,463	2,250.00	1,928.00	-322.00	-14.31
14	ХАЙ БИ ОЙЛ	4,184,234	57.00	49.00	-8.00	-14.04
15	УБ БҮК	7,164	400.00	350.00	-50.00	-12.50



"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК-ИЙН НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИГДАЖ ЭХЭЛЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2-р ангилалд бүртгэлтэй "Хөвсгөл Алтандуулга" ХК нийт 4.4 сая ширхэг буюу нийт хувьцааныхаа 28%-тай тэнцэх хувьцааг нэмж гаргах замаар 3,74 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр олон нийтээс 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл анхдагч зах зээлийн захиалгыг авсан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг СЗХ-ноос өгсөн чиглэлийн дагуу 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хүлээн авч дууслаа.

"Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн анхдагч зах зээлийн захиалгад нийт 100 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 4,405,600 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгснөөр нэмэлт үнэт цаас гаргах үйл ажиллагаа амжилттай болж хоёрдогч зах зээлийн арилжаа арилжигдаж эхэллээ.

"МАНДАЛ ДААТГАЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН НЭЭЛТ, ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд шинээр бүртгэгдсэн "Мандал даатгал" ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг нээж цан цохих ёслолын үйл ажиллагаа 2018.09.04 –ний өдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дэд дарга Д.Баярсайхан, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Мандал даатгал" ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг, "Мандал даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан болон "Голомт Капитал УЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Амарбаясгалан нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,799 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

"Мандал даатгал" ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, нийт 46 мянга гаруй даатгуулагчидтай, хураамжийн орлогоор даатгалын зах зээлийн 21 хувийг эзэлж буй тэргүүлэгч компаниудын нэг юм.

Тус компани нь нийт хувьцааныхаа 25 хувь буюу 1,560,754 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 4800 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 7.49 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр үнэт цаасны худалдан авах захиалгыг өнөөдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 15 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд анхдагч зах зээлийн арилжаанд 861 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 1,916,207 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 23 хувиар давсан үзүүлэлтэйгээр хаагдлаа.

"АРД ДААТГАЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН НЭЭЛТ, ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд шинээр бүртгэгдсэн "Ард даатгал" ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг нээж цан цохих ёслолын үйл ажиллагаа 2019.09.17-ны өдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Ард даатгал" ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах, "Би Ди Сек УЦК" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,808 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

1994 онд байгуулагдсан, Монголын анхны хувийн даатгалын компани болох "Ард даатгал" ХК нь Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлж буй даатгалын салбарын анхдагч компанийн нэг бөгөөд нийт 24 салбар, 238 төлөөлөгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нийт хувьцааныхаа 30 хувь буюу 7,500,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 700 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 5.25 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр үнэт цаасны худалдан авах захиалгыг 2018.09.17-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 14 цаг хүртэл хүлээн авлаа.

"Ард Даатгал" ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд 1,367 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 9,954,848 ширхэг хувьцаа худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 32.7 хувиар давсан үзүүлэлт боллоо.

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙГ НЭГДСЭН БАЙДЛААР ШИНЭЧИЛЛЭЭ

Хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нөлөөлөх гол мэдээллүүдийн нэг нь тухайн хувьцаат компанийн нөлөө бүхий буюу 5-аас дээш хувь эзэмшигчдийн мэдээлэл байдаг билээ. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь энэхүү мэдээллийг олон улсын жишгийн дагуу ил тод, нээлттэйгээр хөрөнгө оруулагчдад мэдээлэх, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.7 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын хэрэгжилтийг хангуулахад анхааран ажиллаж байна.

Үүний хүрээнд нийт хувьцаат компаниудын 2018 оны 7 дугаар сарын сарын 31-ний өдрийн байдлаар бүртгэлтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг Монгол, Англи хэл дээр нэгдсэн байдлаар шинэчлэн цахим хуудсандаа байршууллаа.



БҮРТГЭЛТЭЙ ЗАРИМ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХӨРВӨХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР СЗХ-НД САНАЛ ХҮРГҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид төрийн өмч хувьчлалын хүрээнд бүртгэгдсэн зарим компаниудын хувьцааны төвлөрөл өндөр, арилжааны идэвх сул байдгаас тэдгээр компаниудын хувьцааны зах зээлийн үнэ болон дансны үнийн хооронд хэт зөрүү үүсч, улмаар тухайн хувьцааны хөрвөх чадвар болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл бий болж байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын чанарыг сайжруулах зорилгоор, хөрвөх чадвар хангалтгүй нэр бүхий 130 компани, үүргийн хэрэгжилт хангалтгүй 95 компани, арилжаа нь зогссон 32 компанид тус тус гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгснөөс гадна эдгээр компаниудын зах зээлийн ханш болон дансны үнийн зөрүүг багасгах талаар авах арга хэмжээний саналыг СЗХ-нд хүргүүлсэн байна.

"АЛТАЙН ЗАМ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ НЭЭЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 3-р ангилалд бүртгэлтэй "Алтайн зам" ХК-ийн үнэт цаас цөөн тоогоор, үнийн огцом өсөлтгүйгээр удаа дараа арилжаалагдсантай холбогдуулан тус үнэт цаасны арилжааг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс зогсоож, зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан нь хянан шийдвэрлэгдсэн тул СЗХ-ны Улсыг байцаагчийн 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 49 тоот албан шаардлагын дагуу үнэт цаасны арилжааг 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрөөс нээлээ.

"ГЕРМЕС ЦЕНТР" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Гермес центр" ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 8-р сарын 31-ний өдрийн №1 тоот тогтоолоор 2018 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 5 төгрөг буюу нийт 392.7 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 9-р сарын 10-ны өдрөөр гаргаж "ҮЦТХТ" ТӨХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

"ЗООС ГОЁЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Зоос Гоёл" ХК-ийн 2017 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэр гаргасныг үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороо "Зоос Гоёл" ХК-ийг үнэт цаасны бүртгэлээс хассан.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрх үүссэн өдөр: **2018 оны 08 сарын 29-ний өдөр**

Хувьцааг* эргүүлэн худалдан авах үнэ: **289,440 төгрөг**

Жич: СЗХ-ны 2015 оны 366 тоот тогтоолын дагуу нэгтгэгдсэн 1 бүхэл хувьцаа (1 бүхэл=366 тоот тогтоолоос өмнөх 288 ширхэг хувьцаа)

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авах эцсийн өдөр: **2018 оны 10 сарын 15-ны өдөр**

Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчид "Зоос Гоёл" ХК-ийн Өөрчлөн байгуулах комисс эсхүл "Би Ди Сек ҮЦК" ХК-д хандана уу. Шаардах эрх хэрэгжүүлэхтэй холбоотой заавар журам, бусад мэдээллийг компаниас болон компанийн цахим хуудаснаас авах боломжтой.

"Зоос Гоёл" ХК, ӨБКомисс:

Хаяг: УБ, ЧД 4-р хороо Ж.Самбуугийн гудамж-22 / өөрийн байр/ 205 тоот

Утас: 11-323306; 11-321907,
И-мэйл: info@zoosgoyol.mn Веб: zoosgoyol.mn

Ажиллах цагийн хуваарь: Даваа-Баасан гарагт 09.00-18.00 цагийн хооронд

"Би Ди Сек ҮЦК" ХК:

Хаяг: УБ, СБД 8-р хороо Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр

Утас: 11-313108; 11-321763, И-мэйл хаяг: info@bdsec.mn

Ажиллах цагийн хуваарь: Даваа-Баасан гарагт 09.00-18.00 цагийн хооронд



"ЛЮКС ЗАНАДУ ГРУПП" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ГАРГАЛАА

"Тозавеллнесс сервисес" ХХК нь "Люкс занадугрупп" ХК-ийн хяналтын багцыг худалдан авсан тул "Компанийн тухай" хуулийн 57.1, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 22 дахь заалт, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, худалдан авах үйл ажиллагааны журам"-ын 3.1-д заасан үүргийн дагуу бусад хувьцаа эзэмшигч нарын өмчлөлд байгаа нийт 43,094 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 890 / сүүлийн 6-н сарын жигнэсэн дундаж ханш/ төгрөгөөр худалдан авах тендер санал гаргаж байна.

Санал болгож буй үнэ: 890 /
найман зуун ерөн/ төгрөг

Худалдан авах тоо ширхэг: 43,094 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

Худалдан авагчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо Үндсэн хуулийн гудамж, Их Үйлсийн эрэлд ХХК-ийн байр 210 тоот

Хувьцаа эзэмшигчдийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16, Реженс Резиденс, 3-р давхарт 314 тоот / Монгол шуудан 48-р салбар/ Дэлгэрэнгүй мэдээллийг 99777951 утсаар авна уу.

"ТАВАН ТОЛГОЙ" ХК-ААС ИРҮҮЛСЭН МЭДЭГДЭЛ

Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй "Таван толгой" ХК-ийн түр хугацаанд зогсоод байсан нүүрс борлуулалтын үйл ажиллагаа 2018 оны 08 сарын 16-ны өдрөөс эхлэн хэвийн явагдаж эхэллээ. Ингэснээр Тавантолгой-Цагаанхад, Цагаанхад – Ганцмод боомт чиглэлийн дагуу коксжих, сул коксжих болон коксжих чанаргүй ангиллын нүүрсийг борлуулж байна.

Харин Тавантолгой-Ганц модны боомт чиглэлд үүсээд байгаа 50-70 км урт цуваа бүхий тээврийн замын ачаалал буурч, замын ачаалал хэвийн болсон тохиолдолд Тавантолгой-Ганцмод /уртын урт/ чиглэлд нүүрс тээвэрлэн борлуулж, экспортын орлогоо нэмэгдүүлэх боломжтой болох юм.

Борлуулалт зогссон хугацаанд компанийн дотоод ажлуудаас гадна хөрс хуулалт болон бусад өдөр тутмын ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан нь борлуулалтыг нэмэгдүүлэх боломжийг бий болгож байна гэж компанийн зүгээс мэдээллээ.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН"-ЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭГДЭЛ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци Баянхонгор аймагт байрлах өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн нөөцийг Канад улсын нөөц тайлагнах NI 43-101 ("National Instrument 43-101" эсвэл "NI 43-101" гэх) тайлагналын стандартын дагуу олон нийтэд танилцуулсан байна.

Энэхүү мэдээнд 2018 оны 5-р сард танилцуулсан Алтан Нар ордын нэмж шинэчилсэн нөөцийн тайланг Баян Хөндий ордын нөөцийн тайлантай нэгтгэн танилцуулсан бөгөөд дээрх хоёр орд нь шинээр илрүүлсэн Хөндий алтны дүүрэгт оршдог бөгөөд эрдэсжилт нь газрын гадаргаас ойр, өндөр агуулгатайгаараа онцлог юм.

"МАТЕРИАЛ ИМПЕКС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Материал импекс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 01 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.11.02-ны өдрийн 10:30 цагт

Бүртгэх өдөр: 2018.10.12-ны өдөр

Хуралдах газар: БГД-ийн 4-р хороо, Нарны зам 16/5, "Материал импекс" ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. "Материал Импекс" ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулах эсэх;

2. ББСБ үүсгэн байгуулах бол дүрэмд өөрчлөлт оруулах.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ажлын өдрүүдэд БГД-ийн 4-р хороо, "Материал импекс" ХК-ийн байранд ирэх эсхүл харилцдаг брокерын компаниас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Хурал зохион байгуулах коммис: 70079924, 96051933

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN